

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Соёл урлагийн газрын төсвийн шууд захирагчийн баталсан 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй харьцуулан жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээр үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж гаргаснаар, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу нэгтгэн боловсруулан баталж жилийн хугацаанд хэрэгжүүлсэн Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн тайлан холбогдох нотлох баримт, материал, судалгаанд үндэслэн асуудал хариуцсан нэгжээс нэмэлт тайлбар, тодруулга авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулан бататгах ажлыг гүйцэтгэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг ашиглан гүйцэтгэсэн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн 20, 60 арга хэмжээний тус бүрийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт болон жилийн эцсийн зорилтот түвшинтэй харьцуулан үнэлсэн..

Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд:

- “Үр дүнтэй” 100 хувь;
- “годорхой үр дүнд хүрсэн” 70 – 100 хүртэл хувь
- “эрчимжүүлэх шаардлагатай” 30 – 70 хүртэл хувь;
- “үр дүнгүй” 0- 30 хүртэл хувь үнэлгээг тус тус гаргасан.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн үнэлгээний задаргаа

№	Дэс дугаар	Арга хэмжээний	Гүйцэтгэлийн хувь
Стратеги зорилт 2.4.1. Үндэсний болон дэлхийн сонгодог урлаг, орчин үеийн урлагийн төрөл зүйлийг жигд хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хүн амд хүртээмжтэй, чанартай урлагийн үйлчилгээг үзүүлэх, төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, шуурхай удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулах,			
Зорилт-1.Салбарын хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах			100%
1.	1.1	“Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулах,	100%
	1.2	“Соёлын орчин, орон зайг бүрдүүлж хөгжүүлэх” арга хэмжээ үндэсний хэмжээнд зохион байгуулах,	100%
	1.3	Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах ажиллагааг зохион байгуулах,	100%
	1.4	“Түүхийн хүрд” баримтат кино бүтээх ажлыг зохион байгуулах,	100%
	1.5	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн Соёл, урлагийн арга улс орон даяар зохион байгуулах хэмжээг зохион байгуулах,	100%
	1.6	Хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах ажиллагааг зохион байгуулах,	100%
	1.7	Кино үйлдвэрлэлийн салбарт зохиогчийн эрхийг хамгаалах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, дэмжих,	100%
Зорилт-2.Хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, бодлого хөтөлбөрийг боловсруулах, дэмжлэг үзүүлэх,			93%
2.	2.1	Салбарын болон байгууллагын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журмын төсөлд санал өгөх	100%
	2.2	Хүчирхийлэл, түрэмгийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох арга хэмжээ авах ажлын хүрээнд өргөн нэвтрүүлгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад мониторинг судалгаа хийх,	100%
	2.3	Олон нийтийн зөвлөл байгуулах санал боловсруулж хүргүүлэх,	90%
	2.4	Дүрслэх урлагийн болон хөгжмийн зохиолын шилдэг бүтээлийг шалгаруулах, улсын санд худалдан авах, хадгалах, ашиглах журмын төсөлд санал боловсруулж хүргүүлэх,	90%
	2.5	Үндэсний их баяр наадмын тухай хуулийн төсөлд санал боловсруулж хүргүүлэх,	90%
	2.6	Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батлах,	100%

Зорилт-3.Үндэсний болон дэлхийн сонгодог, орчин үеийн урлагийн төрлийг хөгжүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайханд чиглүүлэх, чанартай, иргэдэд ээлтэй хүртээмжтэй үйлчилгээг нэмэгдүүлэх, урлагийн боловсролыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих,		73%	
3.	3.1	Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан 100 жил 100 бүтээн байгуулалт телевизийн контент бүтээх ажлыг зохион байгуулах,	70%
	3.2	Мэргэжлийн урлагийн байгууллага, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувь хүн уран бүтээлчдэд бодлого, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх,	100%
	3.3	Хүүхэд, залуучуудын авьяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг урамшуулж, соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжих талаар аймаг, нийслэлийн соёл урлагийн газартай хамтран ажиллах,	50%
Зорилт-4.Урлагийн байгууллагуудын менежментийг сайжруулах, соёлын үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлж салбарын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр чадавхийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг боловсруулах хэрэгжүүлэх,		100%	
4.	4.1	ЗГ-ын 2008 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан журам. Оны шилдэг уран бүтээлч шалгаруулах “Мөнгөн мод” арга хэмжээг зохион байгуулах,	100%
	4.2	Мэргэжлийн урлагийн байгууллагуудын урын сангийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах,	100%
	4.3	“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд нийслэл, орон нутгийн соёл урлагийн байгууллагуудын оролцоог хангасан бүтээлч үйл ажиллагаа зохион байгуулах,	100%
	4.4	Монгол уран бүтээл, монгол уран бүтээлчийг үндэсний болоод олон улсад сурталчлан таниулах, үйл ажиллагааг дэмжих,	100%
Зорилт-5.Монгол уран бүтээл, монгол уран бүтээлчийг үндэсний болоод олон улсад сурталчлан таниулах, үйл ажиллагааг дэмжих,		90%	
5.	5.1	Мэргэжлийн урлагийн байгууллага, уран бүтээлчдийг олон улсын уралдаан наадамд оролцох, бүтээл туурвилаа түгээн дэлгэрүүлэх, сурталчилахад нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах,	90%
	5.2	Монголд зочлох жилийн хүрээнд мэргэжлийн урлагийн байгууллагуудын үзвэр үйлчилгээний хөтөлбөрийг нэгтгэн салбарын хэмжээний календарчилсан төлөвлөгөөнд тусган сурталчлах,	90%
Стратеги зорилт 2.4.2. Соёлын өвийг хадгалж хамгаалах, сурвалжлан олох, бүртгэх, өвлөн уламжлуулах, сэргээн засварлуулах, судалгаа шинжилгээ хийх, түгээн дэлгэрүүлэх талаар баримтлах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, соёлын өвийн улсын үзлэгийг улсын хэмжээнд зохион байгуулж, шуурхай удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулах,			
Зорилт-6.Төрөөс соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах,		93%	
6.	6.1	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулах,	90%
	6.2	Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах,	90%
	6.3	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах,	100%
Зорилт-7.Соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, хадгалж хамгаалах, эрсдэлд өртсөн соёлын өвийг авран хамгаалах, сурталчлах		99%	
7.	7.1	“Алтайн өндөр уулс” өвийг Дэлхийн өвийн шинжээчдэд танилцуулах арга хэмжээг хамтран зохион байгуулах	100%
	7.2	“Дэлхийн өв - Бурхан Халдун, Чингис хааны өв, соёл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах	100%

	7.3	Дэлхийн өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдэлийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх	100%
	7.4	“Дэлхийн өв-Бурхан Халдун” соёлын өвийн наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	100%
	7.5	Байгалийн болон бусад шалтгааны улмаас устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	100%
	7.6	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах,	100%
	7.7	БНФУ-ын Нант хотын музейтэй хамтран Чингис хаан болон Монголын хаад язгууртны үзэсгэлэн зохион байгуулах зорилгоор зохион байгуулалтыг хангах,	90%
	7.8	Швейцар улсын Ритбергийн музейтэй хамтран “Нүүдэлчдийн хот байгуулалтын уламжлал” үзэсгэлэн зохион байгуулах зорилгоор зохион байгуулалтыг хангах,	100%
Зорилт-8.Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдыг судалж, хосгүй авьяас арга технологи мэдлэгийг өвлүүлэх, уламжлалт хийгээд орчин цагийн сургалтын хэлбэрүүдийг хөгжүүлэх,			83%
8.	8.1	ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийг хамгаалах арга хэмжээ авах,	70%
	8.2	Урианхай, Тува түмний соёлын өвийн өдрүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх,	90%
	8.3	“Монголын ёс заншил, зан үйлийн талаарх богино хэмжээний баримтат кино бүтээлийн уралдаан зохион байгуулах,	90%
Зорилт-9.Соёлын олон талт ажил, үйлчилгээ бүтээгдэхүүний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх,			98%
9.	9.1	"Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого" сэдэвт соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг хамтран зохион байгуулах хүрээнд "Соёлын төв, соёлын ордны шинэчлэл" салбар хуралдаан зохион байгуулах,	90%
	9.2	"Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд цуврал арга хэмжээг зохион байгуулах,	100%
	9.3	Монголын утга зохиолын бүтээлийг англи хэлнээ орчуулах уралдаан зарлах,	100%
	9.4	"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022" хаврын арга хэмжээг улс орон даяар зохион байгуулах,	100%
	9.5	"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022" намрын арга хэмжээг улс орон даяар зохион байгуулах,	100%
	9.6	Номын сайн нөхөр шалгаруулах уралдааныг улс даяар зохион байгуулах,	100%
Стратеги зорилт 2.4.3. Соёл, урлагийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх, салбарын бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын салбарын дүн бүртгэлийг хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.			
Зорилт-10.Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн, үр дүнг тооцох,			70%
10.	10.1	Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн батлуулахаар хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах,	70%


Зорилт-11.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, захиргааны үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,			100%
11.	11.1	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,	100%
Зорилт-12.Байгууллагын дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх,			70%
12.	12.1	Албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,	70%
Зорилт-13.Салбарын статистик мэдээллээр удирдлага, хэрэглэгчийг хангах,			100%
13.	13.1	Статистик мэдээллийг цуглуулах, мэдээллийн үнэн зөв, бодитой байдалд хяналт тавих,	100%
	13.2	Мэдээллийг нэгтгэх, бүс нутгаар, салбараар, өмчийн хэлбэрээр ангилах,	100%
Зорилт-14.Байгууллагад мөрдөгдөх журмыг шинэчлэн боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах,			70%
14.	14.1	Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Захиргааны зөвлөлийн ажиллах журам”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” төслийг тус тус боловсруулан батлах,	70%
Зорилт-15.Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан батлуулах хэрэгжилтийг хангах,			75%
15.	15.1	Салбарын болон агентлагийн албан хаагчдын 2022 оны сургалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах,	100%
	15.2	Агентлагийн албан хаагчдын 2022 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах,	50%
Зорилт-16.Байгууллагын хүний нөөцийн бүртгэл хөдөлгөөн, хүний нөөцийн холбогдолтой албан хэргийг хөтлөн явуулах,			100%
16.	16.1	Албан тушаалын сул орон тоог нөхөх, албан хаагчдыг ажлын байранд нэр дэвшүүлэх, тангараг өргүүлэх, нээлттэй ажлын байр зарлуулах ажлыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах,	100%
Зорилт-17.Байгууллагын ил тод байдлыг хангах, авилгаас урьдчилан сэргийлэхийг ажлыг зохион байгуулах,			30%
17.	17.1	Байгууллагын захиргааны албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хөрөнгө орлогын мэдүүлгийн журмын биелэлтийн талаарх тайланг холбогдох газарт хүргүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх,	30%
Зорилт-18.Байгууллагын архив, бичиг хэргийн зохион байгуулалтыг сайжруулах,			97%
18.	18.1	Баримт нягтлан шалгах комисс (БНШК)-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах,	90%
	18.2	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивын нэгжийг бүрдүүлэх,	100%
	18.3	Ирсэн, явсан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэх, мэдээлэх,	100%
Зорилт-19.Байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр хангах, сурталчлах,			100%
19.	19.1	Салбарын үйл ажиллагааг олон нийтэд албан ёсоор, бодитой, шуурхай, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, мэдээллийн хүртээмжийг нягтлах, олон нийтийн хариу үйлдлийг тандах ажлыг удирдан зохион байгуулах,	100%

	19.2	Байгууллагын мэдээллийн технологид суурилсан сүлжээ, цахим сайт, пэйж хуудас, албаны мэйл хаяг болон бусад сурталчилгааны бүтээгдэхүүнүүдийг эрхлэх, удирдах;	100%
Зорилт-20.Төсвийн шууд захирагчийн төсвийг хуваарилах, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх,			30%
20.	20.1	Урсгал төсөв болон хөрөнгө оруулалтын төсөв төлөвлөх, батлагдсан төсвийн хуваарь гаргах, төсвийн зарцуулалтыг зохих журмын дагуу эрхлэн явуулах, тайлагнах, удирдлагыг мэдээллээр хангах,	30%
	20.2	Санхүүгийн тайлан тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв нэгтгэн гаргаж, хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлэх,	30%
	20.3	Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, шилэн дансны хэрэгжилтийг хангах, хяналт тавих,	30%
Зорилтын дундаж үнэлгээ			83,5%



Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалын дагуу арга хэмжээг үнэлсэн байдлыг дараах хүснэгт болон графикаар харуулбал:

№	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам	Үнэлгээ				
		6.2.1 дахь заалт	6.2.2 дахь заалт			
1	Арга хэмжээний тоо	100%	90%	70%	50%	30%
		37	12	5	2	4
Арга хэмжээний дундаж үнэлгээ		89%				



Дөрөв.Дүгнэлт

Соёлын сайдын 2021 оны А/45 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах журам”-ын 4.2 дэх хэсэг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа арга хэмжээ тус бүрийн биелэлтийг тооцож, тэдгээрийн дундажаар зорилт тус бүрийн биелэлтийг, зорилтын дунджаар төлөвлөгөөний бизлэлтийг тооцох” тул байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 зорилгын хүрээнд дэвшүүлсэн 20 зорилтын дундаж үнэлгээгээр 83,5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэж байна.

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 70 буюу түүнээс доош үнэлэгдсэн зорилт, арга хэмжээ тус бүрээр дүгнэхэд:

1. Гуравдугаар зорилтын 3.1-т заасан “Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан 100 жил 100 бүтээн байгуулалт телевизийн контент бүтээх ажлыг зохион байгуулах” арга хэмжээний зорилтод түвшинд хүрээгүй гэрээ байгуулах эрх олгож, гэрээ байгуулж, зардал шийдвэрлэсэн нь шаардлагатай ажил бүрэн хийгдэж, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн тул 70 хувьтай үнэлэгдсэн.
2. Гуравдугаар зорилтын 3.3-т заасан “Хүүхэд, залуучуудын авьяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг урамшуулж, соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжих талаар аймаг, нийслэлийн соёл урлагийн газартай хамтран ажиллах” арга хэмжээний шалгуур үзүүлэлт 5 арга хэмжээ зохион байгуулж уран бүтээлч авьяаслаг хүүхэд залуучуудыг дэмжиж ажиллах зорилтод түвшинд хүрсэн тухай тайлагнаагүй тул 50 хувьтай үнэлэгдсэн.
3. Аравдугаар зорилтын 10.1-т заасан “Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн, үр дүнг тооцох” арга хэмжээний шалгуур үзүүлэлтэд 2 төлөвлөгөө батлуулж, үе шаттай хэрэгжүүлэх зорилтод түвшинд хүрээгүй байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлсэн, стратеги төлөвлөгөө боловсруулсан боловч батлуулаагүй байх тул 70 хувьтай үнэлэгдсэн. Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1-т Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталсанаас хойш 2 сарын дотор байгууллагын стратеги төлөвлөгөөг баталж 4 жилийн хугацаатай боловсруулаагүй байна. Мөн Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх заалтийг хэрэгжүүлээгүй байна.
4. Арванхоёрдугаар зорилтын 12.1-т заасан “Албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” арга хэмжээний дотоод хяналт хийх удирдамж батлах шалгуур үзүүлэлтийг хангаж дүгнэлт зөвлөмжөөр хангах зорилтод түвшинд хүрээгүй удирдамж боловсруулсан ч удирдлагын шийдвэрээр

- хойшлуулсан. Албан хаагчийн гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үүрэг бүхий байгууллагын үнэлгээний багийг байгуулсан байх тул тул 70 хувьтай үнэлэгдсэн.
5. Арвандөрөвдүгээр зорилтын 14.1-т заасан “Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Захиргааны зөвлөлийн ажиллах журам”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” төслийг тус тус боловсруулан батлах” арга хэмжээнд байгууллагын хэмжээнд мөрдөгдөх 3 журам боловсруулж батлуулах зорилтод түвшинд хүрээгүй зөвхөн 1 журам батлуулж, 2 журмын боловсруулалт хийгдсэн байх тул 70 хувьтай үнэлэгдсэн.
 6. Арвантавдугаар зорилтын 15.2-т заасан “Агентлагийн албан хаагчдын 2022 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах” арга хэмжээний шалгуур үзүүлэлт төлөвлөгөө баталж, хэрэгжүүлээгүй атал нийгмийн баталгааг хангах талаар арга хэмжээ авч ажилласан тухай тайлагнасан байх тул 50 хувьтай үнэлэгдсэн. Төрийн албан тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт заасан Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй байна.
 7. Арвандолдугаар зорилтын 17.1-т заасан “Байгууллагын захиргааны албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хөрөнгө орлогын мэдүүлгийн журмын биелэлтийн талаарх тайланг холбогдох газарт хүргүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх” арга хэмжээний төлөвлөгөө-1, тайлан-1 шалгуур үзүүлэлтийг авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтод түвшинд хүрээгүй байх тул 30 хувьтай үнэлэгдсэн. МУИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх, тайлагнах үүргээ захиргааны байгууллага хэрэгжүүлээгүй байна.
 8. Хорьдугаар зорилтын 20.1, 20.2, 20.3-т тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд уялдуулан тайлагнаагүй, тайлагналт хангалтгүй түвшинд байна. Байгууллагын үйл ажиллагаа 2022 онд бүрэн явагдсан тодорхой төсөвтэй зорилт, арга хэмжээг дэвшүүлэн хэрэгжүүлсэн байх тул үйл ажиллагаа явагдсан санхүүжилт хийгдсэн гэж төсөөлөн дүгнэж нотлох баримт, тоон мэдээгүйгээр 30 хувь үнэлсэн байна.

Цаашид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын стратеги төлөвлөгөөнд үндэслэн стратегийн зорилгод үндэслэн зорилт арга хэмжээг төлөвлөх түүнчлэн хуулиар олгосон тусгай болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шаардлагыг хангалтгүй зөвхөн байгууллагын стратеги бүтцийн өөрчлөлтөд үндэслэн баталснаар төлөвлөлт бүтцийн хувьд алдаатай хийгдсэн байна.

Мөн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжөөр хангаагүйгээс шалтгаалан Соёл урлагийн газрын Төсвийн шууд захирагчийн бүтэн жилийн ажлын үр дүн, үнэлгээ хангалтгүй үнэлэгдэх урьдчилан нөхцөл бүрдэх эрсдэлтэй тул байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох журмын дагуу хийх нь зүйтэй.

Тав. Зөвлөмж

3.1. Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан 100 жил 100 бүтээн байгуулалт телевизийн контент бүтээх ажлыг зохион байгуулах арга хэмжээг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үргэлжүүлэн тусгаж ажиллахыг Урлаг, уран бүтээлийн хэлтэст;

3.2. Хүүхэд, залуучуудын авьяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг урамшуулж, соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжих талаар аймаг, нийслэлийн соёл урлагийн газартай хамтран ажиллах арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхүйц төлөвлөлтийг нэгжийн болон асуудал хариуцсан мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллахыг Урлаг, уран бүтээлийн хэлтэст;

10.1. Байгууллагын стратеги батлуулах арга хэмжээг эрчимжүүлэхийг Захиргааны хэлтэст;

12.1. Албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга хэмжээг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Захиргааны хэлтэст;

15.1. Салбарын болон агентлагийн албан хаагчдын 2022 оны сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг ханган сургалтын төлөвлөгөөний тайланг нэгтгэн танилцуулахыг Захиргааны хэлтэст;

15.2. Агентлагийн албан хаагчдын 2022 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Захиргааны хэлтэст;

17.1. Байгууллагын захиргааны албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хөрөнгө орлогын мэдүүлгийн журмын биелэлтийн талаарх тайланг холбогдох газарт хүргүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлуулж байгууллагын цахим хуудаст байршуулан хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг Захиргааны хэлтэст;

Зорилт 20-г тусгагдсан 3 арга хэмжээг хэрэгжүүлж тайлагналтыг шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд уялдуулан хэрэгжүүлж үндэслэл бүхий тоо баримттай тайлагнаж байхыг Захиргааны хэлтэст;

2022 оны жилийн эцсийн тайланг тайлагнахдаа үр дүнг үнэн бодитой, иж бүрэн, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв тайлагнах, эрчимжүүлэх шаардлагатай үнэлгээ авсан арга хэмжээнүүдийг анхаарч ажиллахыг Захиргааны хэлтэст;

Байгууллагын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг баталж байгууллагын гүйцэтгэлийн Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, тухайн жилийн зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, суурь түвшинг тооцоо судалгаанд үндэслэн бодитой тодорхой тусгах, нэгжүүдээс саналыг авч төлөвлөж ажиллахыг Захиргааны хэлтэст үүгээр зөвлөж байна.

Боловруулсан:
Захиргааны хэлтсийн
Ахлах мэргэжилтэн

С.Номин